

## ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Ч.Дагвадорж (PhD), төслийн зөвлөх  
Нийгмийн хамгааллын салбарын  
шинэчлэлийн хөтөлбөр төсөл

*Хүн амын нийгмийн хамгааллын тухай асуудал онол, арга зүйн талаасаа нарийвчлан судлагдаж дорвитой хариу авч чадаагүй, маргаантай асуудлуудын нэг байсаар байна.*

*Нийгмийн хамгааллын асуудлыг авч үзэхийн тулд юуны өмнө Хэнийг? Юунаас? Яаж? хамгаалах вэ гэсэн асуултуудыг тодорхойлох шаардлагатай байна. Нийгмийн хамгааллыг өргөн утгаар нь авч үзвэл Монгол улсын 2.4 сая хүн ам бүгдээрээ нийгмийн хамгааллын системд хамрагдаж, өөрт шаардлагатай эрх мэдэл, өмч хөрөнгө, амьдралын нөхцлийг нийгмээс хүртэх эрхтэй гэсэн үг юм.*

*Иймд улс, орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь нийгмийн зөвшилцөл дээр үндэслэсэн, сайтар бодож, боловсруулсан нийгмийн хамгааллын систем юм.*

*Харин манайд нийгмийн хамгааллыг явцуу хүрээнд тухайлбал, даатгал, нийгмийн халамж, нийгмийн бодлого дахь хамгааллын асуудлаар дамжуулан хүн амын амьдралын хамгааллын асуудлын хүрээнд авч үзсээр байна.*

### 1. Оршил

Америк, Герман, Япон зэрэг эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудад хүн амын нийгмийн хамгааллын систем нь төлөвшиж, ядуурал, ажилгүйдэл зэрэгт түүртэхээргүй болж, ард иргэдийн нь ая тухтай амьдрах нөхцөл нь бүрджээ. Өөрөөр хэлбэл, иргэдийнх нь амьдралын баталгаа хангагдсан гэсэн үг юм. Ер нь аливаа оронд хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэж чадсанаар эдийн засаг нь хөгжих боломж нээгдсэн үү? Эдийн засаг нь хөгжсөнөөр хүн амын нийгмийн хамгааллын асуудал нь шийдвэрлэгдсэн үү? гэдэг л нийгмийн хамгааллын системийн агуулга, мөн чанарыг тодорхойлдог ажээ. Улс, орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь нийгмийн зөвшилцөл дээр үндэслэсэн, сайтар бодож, боловсруулсан нийгмийн хамгааллын системтэй холбоотой гэдэгтэй эрдэмтэд, судлаачид сүүлийн жилүүдэд санал нэгдэхэд хүрээд байна. Гэхдээ хүн амын нийгмийн хамгааллын тухай асуудал онол, арга зүйн талаасаа нарийвчлан судлагдаж дорвитой хариу авч чадаагүй, маргаантай асуудлуудын нэг хэвээр байна. Нэрний хувьд ч нарийвчлан тогтоогүй “нийгмийн хамгаалал”, “бүх нийтийн хангалуун байдал”, “нийгмийн үйлчилгээ”, “эдийн засгийн хамгаалал”, “нийгмийн дэмжлэг” гэх мэт олон янзаар нэрлэж байхад хамрах хүрээний хувьд “бүх нийтийг хамрах”, “эмзэг хэсгийг хамгаалах”, “ажилчдыг хамруулах” гээд олон хувилбарыг улс орон бүрт өөр өөрөөр хэрэглэж байна.

## **2. Нийгмийн хамгааллын онол- арга зүйн үндэслэл**

Иргэдийг нийгмийн шинжтэй эрсдлээс хамгаалах, тэдэнд туслах асуудлыг онол, арга зүйн талаас нь судлах, үйл ажиллагааг нь төрийн үүрэг болгон хэрэгжүүлэх шаардлагыг XVII зуунаас эрчимтэй хөгжсөн үйлдвэржүүлэлт, хотжилт, байгалийн баялгийн ашиглалт, хүмүүсийн амьдралын түвшний эрс ялгаа, нийгмийн гишүүдийн хоорондын харьцаанд гарсан өөрчлөлтүүдийн эерэг, сөрөг үр дүн бий болгожээ. Эдгээрийн үр нөлөөгөөр нийгмээс шоовдорлогдсон, ядуурал, ажилгүйдэл, гуйланчлалд өртсөн хүмүүст нийгмийн гишүүний хувьд нь туслах тухай ихээр яригдаж, нийгмийн томоохон асуудал болж тавигдсан. Францын Сен-симонизм, Английн Фабионы нийгэм, Германы Ферейн-фер-социаль-политик зэрэг XIX зууны нийгэм, улс төрийн хөдөлгөөн ч нийгмийн нөхцөл байдлыг өөрчлөхөд онол, арга зүйн хувьд чухал нөлөө үзүүлжээ. Тэрчлэн тухайн үеийн нийгмийн нөхцөл байдал, захиалгаар XVIII зууны төгсгөл, XIX зууны эхэн үед нийгмийн шинжлэх ухаан, түүний дотроос нийгмийн хамгааллын онол арга зүйн үндсийг тавьсан Сен Симон, Шарль Фурье, Аугусто Комте, Карл Маркс нарын чухал бүтээлүүд гарсан бөгөөд тэд нийгмийн хамгааллыг гол төлөв ажилчин ангид хандуулснаараа онцлог бөгөөд эргэлзээтэй юм. Нийгмийн хамгааллын онол, арга зүйг үндэслэгчдийн үзэл санаа нь өнөөгийн судалгаа шинжилгээний ажлын үндэс болсоор байна. Карл Марксын дэвшүүлсэн зүүний буюу нийгмийн хамгааллын тухай ардчилсан социалист онол, арга зүй нь орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны сэтгэлгээнд томоохон байр суурийг эзэлдэг бөгөөд зөвхөн онолын сэтгэлгээний ололт, судалгааны ажлын үр дүн төдийгүй ардчилсан социализмын үзэл буюу Шведийн загварын хувилбараар нийгмийн хөгжилд бодит биеллээ олжээ. Энэ онолын арга зүйн үндэс нь иргэн бүрийн ажил эрхлэлт, өндөр цалин хөлс, чинээлэг хангалуун амьжиргаа, олон ургалч үзэл, улс төрийн ардчилал, байгаль орчны хамгаалал зэрэг асуудлууд багтжээ. Ардчилсан социалист онолын арга зүй нь өнөөгийн Европын холбооны хэмжээнд баримталж байгаа нийгмийн баримжаат зах зээлийн бодлогыг боловсруулах суурь болсон. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн үзэл баримтлалын нийгмийн хамгааллын зарчмууд нь ардчилсан социализмынхаас нэлээд өөр боловч бодит үр дүн нь ойролцоо бөгөөд төсөөтэй байна. Хэдийгээр сүүлийн үед зарим нэг талаараа Шведийн загвар мухардалд ороод байгаа ч ардчилсан социалист үзэл зөвхөн Европт төдийгүй дэлхийн олон оронд, түүний дотроос Австрали, Япон, Монгол оронд ч хэсэгчлэн хэрэгжиж байна.

Түүнчлэн Рио де Жанейро хотноо 1992 онд чуулсан дэлхийн дээд хэмжээний уулзалтаас “Тогтвортой хөгжил”-ийн онол, үзэл баримтлалыг шинэ зуун дахь дэлхийн бүх улс орнуудын хөгжлийн ирээдүй болгон дэвшүүлэн тавьсан билээ. Түүнд нийгэм /хүн/-эдийн засаг-байгаль орчин гэсэн гурвалсан зорилт, шалгуур, түгээмэл зарчим, хүчин зүйл, холбоо хамаарлыг тунхагласан билээ. Энэхүү тунхаглалын үзэл санаа нь өнөөдөр дэлхийн бүх улс оронд түгэн дэлгэрч, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зарчим, хөтөлбөр хэлбэрээр хэрэгжиж байна. Гэхдээ нийгмийн хамгаалал нь улс орон, бүс нутаг, үндэстэн угсаатны хувьд өөрийн онцлогтой. Өөрийн орны нийгэм, эдийн засгийн онцлог, уламжлалт соёл иргэншилд тохирсон онол, арга зүйн үндсэн дээр нийгмийн хамгааллын системийг төлөвшүүлж чадвал дээр дурьдсан нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилтын үндэс нь болдог ажээ.

## **3. Нийгмийн хамгаалал гэж юу вэ?**

“Social security” буюу бидний нэрлэж эхлээд байгаа “нийгмийн хамгаалал” гэдэг үг XX дугаар зууны дунд үеэс хэрэглэгдэж эхэлсэн латин гаралтай шинэ үг гэж

судлаачид үздэг. “Security “ нь англиар “ Se-curus” гэсэн үгнээс бүтдэг бөгөөд “se” гэдэг нь “liberation” буюу чөлөөлөлт, “curus”- гэдэг нь “uncasiness” буюу эвгүй, тавгүй, тайван бус гэж үгчлэн орчуулагдаж болох юм. Гэхдээ “ард иргэдийг нийгмийн шинжтэй эрсдлээс хамгаалах” гэсэн утгаар ихэнх оронд хэрэглэгдэж байна. Нийгмийн хамгаалал буюу “Social security” гэдэг үгийг хуулийн хэлэнд анх удаа 1935 онд Америкт хэрэглэснээр өндөр насны тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгалын систем, төрийн халамжийн систем бүрдэх үндэс болжээ. 1938 онд Шинэ Зеландад нийгмийн хамгаалал(Social security)-ын тухай хууль батлагдсаныг 1942 онд хэвлэгдсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын илтгэлд “нийгмийн хамгааллын системийн шинэ загвар” гэж тэмдэглэснээр энэ үг өргөн хэрэглэгдэх болжээ.

Улс орнуудад “нийгмийн хамгаалал” гэдгийг янз бүрээр ойлгож, хэрэглэж байна.

- Японоор нийгмийн хамгааллыг “shakaihoshho” гэж нэрлэдэг бөгөөд “эрсдэлээс нийгмийн системээр хамгаалах” гэсэн утгыг илэрхийлдэг. Японы нийгмийн хамгааллын системд хүнийг төрөхөөс үхэх хүртэлх өвчлөл, осол гэмтэлд өртөх, тахир дутуу болох, ажилгүйдэх, хөгшрөх зэргийг бүхэлд нь хамарсан тэтгэвэр, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн даатгал, төрийн халамж, хүүхэд, тахир дутуу иргэд, ахмад настны хамгааллын асуудлууд ордог.
- Франц улсад нийгмийн хамгааллын системийг “Protection Social” гэж нэрлэдэг бөгөөд нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийгмийн үйлчилгээ болон орлогын доод түвшингийн хамгаалалтын асуудлыг хамруулдаг.
- Америкийн нийгмийн хамгаалалд тэтгэвэр, орлогын хамгааллыг хамруулдаг бөгөөд халамжийн үйлчилгээг “хүний үйлчилгээ” буюу “Human services” гэж нэрлэн татвараар хуримтлагдсан сангаас цаг үеийн зайлшгүй шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлдэг байна.
- Англи улсын Нийгмийн хамгааллын системд нийгмийн хамгаалал-”Social security”, нийгмийн бодлого-”Social policy”, нийгмийн үйлчилгээ-”Social services” гэсэн 3 ойлголтыг хамруулж, орлогын хамгаалалт, эрүүл мэндийн үйлчилгээ, орон байрны бодлого, хөдөлмөр эрхлэлт, боловсролын асуудлыг багтаадаг.
- Германы нийгмийн хамгаалал “Sozial Sicherheit”-д нийгмийн даатгал, нөхөн төлбөр, нийгмийн дэмжлэг зэргийг багтаадаг бөгөөд нийгмийн халамж- “Sozial Wohlfahrt” гэж тэр болгон ярьдаггүй байна.

Монгол улсад 1940-өөд оноос “нийгмийн хангамж” гэсэн үгийг хэрэглэж ирсэн боловч зах зээлийн харилцаанд шилжсэн сүүлийн жилүүдэд “нийгмийн хамгаалал” гэж яригдах болоод байна. Монгол хэлний тайлбар толь бичигт “нийгмийн хангамж” гэдгийг “хөдөлмөрчдийг тахир дутуу болох, нас өндөр болох, асрамжлах хүнгүйд хүрэх зэрэгт тэдгээрийг улсаас тэтгэн туслах зардал, төсөв”<sup>1</sup> гэж тайлбарласан байдаг.


Нийгмийн хамгааллын тухай ойлголтыг тодруулахын тулд эхлээд Хэнийг хамгаалах вэ? Юунаас хамгаалах вэ? Яаж хамгаалах вэ? гэсэн асуултуудыг тодорхойлох шаардлагатай.

***Хэнийг , юунаас, яаж хамгаалах вэ?***

---

<sup>1</sup> Я. Цэвэл □Монгол хэлний товч тайлбар толь□ 374-р тал.

Хэнийг хамгаалах вэ? гэсэн асуудлаас нийгмийн хамгааллын хамрах хүрээ, ойлголтын цар хэмжээ тодорхойлогддог.



Тухайн улсын бүх иргэдийг, хүмүүнлэг иргэний нийгмийн бүх гишүүдийг нийгэм нь хамгаалах ёстой гэж үзвэл нийгмийн хамгаалал “өргөн утгаараа” ойлгогдож, хамрах хүрээ, хариуцах асуудал нь эрс өргөждөг. Энэ тохиолдолд эмзэг бүлгийн бие даан амьдрах чадваргүй иргэдээс эхлээд үйлдвэрийн эзэд, ажил олгогчийг хамарсан, тэтгэвэр, тэтгэмж, асрамж үйлчилгээнээс эхлээд татвар, гааль, зээл, санхүүгийн механизмыг багтаасан, халамжийн үйлчилгээнээс эхлээд эдийн засаг, нийгэм, эрх зүй, улс төрийн хүрээг хамарсан ойлголтыг бий болгодог.

Иймээс нийгмийн хамгааллыг өргөн утгаар нь дараах байдлаар ойлгож болно.

Нийгмийн гишүүн бүрийн ажил эрхлэлт, боломжит цалин хөлс, чинээлэг хангалуун амьжиргааг бүрдүүлэхэд чиглэгдсэн нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны цогц арга хэмжээг нийгмийн хамгаалал

Нийгмийн хамгааллыг энэхүү өргөн утгаар нь авч үзсэн нөхцөлд нийгмийн бүх гишүүд энэ системд хамрагдах ёстой. Өөрөөр хэлбэл, Монгол улсын 2.4 сая хүн бүгдээрээ нийгмийн хамгааллын системд хамрагдаж, өөрт шаардлагатай эрх мэдэл, өмч хөрөнгө, амьдралын нөхцлийг нийгмээс хүртэх эрхтэй гэсэн үг. Гэхдээ нийгмийн бүлэг бүрийн онцлогт тохирсон, тэднийг хамгаалах, халамжлах, асрамжлах төрийн бодлого, эрх зүйн орчин, түүнийг хэрэгжүүлэх арга, механизмыг тодорхойлох шаардлагатай болдог.

Бүх иргэдийг нийгмийн хамгаалалд хамруулахдаа нийгэмд гүйцэтгэх үүрэг, ажил эрхлэх чадвараар нь эдийн засгийн идэвхтэй хүн ам, тусламж дэмжлэг хүртэгчид гэж хоёр ангилж тус бүрт нь тохирсон нийгмийн хамгааллын арга, механизм хэрэглэх нь зөв юм. Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажил олгогч-эзэд, ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ардын аж ахуйтнууд, албан бус секторынхан, бие даасан уран бүтээлчид болон түр хугацаагаар ажилгүй байгаа хөдөлмөрийн чадвартай хүмүүс багтана. Тусламж, дэмжлэг хүртэгчдэд хөдөлмөр эрхлэх бололцоогүй бие эрхтний эмгэгтэй иргэд, өнчин хүүхэд, өтөл настнуудыг хамааруулдаг.

Эдийн засгийн идэвхтэй хүмүүсийг дотор нь ажил олгогч-ээд, ажиллагчид, ажилгүйчүүд гэж гурав ангилвал тус бүрийн онцлогт нь тохирсон, ялгавартай нийгмийн хамгааллын арга, хэлбэр, механизмыг бүрдүүлэх боломжийг бий болгодог.



**Ажил олгогч** нарт хөрөнгө өмчлөх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах зэрэг үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээний бүх шатанд ажиллах нөхцлийг бүрдүүлж, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгмийн талаас нь дэмжиж туслах нь тэдний нийгмийн хамгааллын үндсэн асуудал юм.

*Улс төрийн хүрээнд* сонгох, сонгогдох, хэвлэх, нийтлэх, эрх ашгаа хамгаалах зэрэг нөхцлийг бүрдүүлнэ.

*Эдийн засгийн хүрээнд* татвар, гааль, санхүү, зээл, эдийн засгийн урамшууллын механизмаар дамжуулан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхцлийг бий болгоно.

*Эрх зүйн хүрээнд* эзэд, ажил олгогчийн өмчлөх, үйлдвэрлэх, үйлчлэх, борлуулах эрх ашгийг хууль, тогтоомжоор хамгаална.

*Нийгмийн хүрээнд* тэдний нэр хүнд, нийгмийн идэвх, санаачлага, оролцоог хамгаалах нь чухал байдаг.

Эзэд-ажил олгогчийн нийгмийн хамгааллын асуудлыг нь зөв шийдвэрлэж чадвал ажлын байр нэмэгдэж, үндэсний орлого өсөж, бүх нийтийн хангалуун амьдрал бий болох нөхцлийг бүрдүүлдэг гэдгийг АНУ, Япон, Герман, Швед зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо төлөвшсөн орнуудын туршлагаас харж болно. Харин эзэд-ажил олгогчийн нийгмийн хамгааллын асуудалд ач холбогдол бага өгсөн орнуудад үндэсний үйлдвэрүүд дампуурч, ажилгүйчүүдийн тоо нэмэгдэж, эдийн засаг уналтанд орж, нийгмээс халамж хүсэгчдийн тоо эрс нэмэгдэхэд хүрдэг. Ийм үзэгдэл социалист чиг баримжаагаар хөгжиж байгаад 1990-ээд оны эхээр зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн орнуудад өргөн тохиолдсоны нэг нь Монгол улс. Монгол улсад 1990-1997 онд олон мянган компани, хоршоо, хувиараа эрхлэх аж ахуйнууд шинээр байгуулагдсан боловч олон арван нь дампуурч үгүй болсон нь үйлдвэрлэл явуулах нөхцөл бүрдээгүй, эзэд-ажил олгогчийн мэдлэг чадвар хангалтгүй, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого сул, тэднийг татвар, зээлийн хүү, гаалийн бодлого, эдийн засгийн урамшуулал зэргээр дэмжээгүйтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, эдийн нийгмийн хамгааллын бодлого энэ үед ихээхэн алдагдсан болж таарах юм. Эзэд-ажил олгогч нар ажиллагчдынхаа ирээдүйн амьдралын төлөө хөрөнгө хуримтлуулахад идэвхтэй оролцож, нийгмийн даатгалын сан бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг боловч өөрсдийнхөө төлөө, сайн дурын үндсэн дээр даатгалд хандах нь хангалтгүй, олон жилийн турш хамгааллын гадна явж ирсэн нь үйлдвэрлэл дампуурсан, өмч хөрөнгө үрэгдсэн нөхцөлд нийгмийн даатгалын сангаас тусламж авах эрхгүй үлдэх магадлалтай. Эзэд-ажил олгогчдыг зөв зохистой дэмжвэл ажиллагчдын нийгмийн хамгааллын асуудал ч давхар шийдвэрлэгддэг.

**Ажиллагчдын** нийгмийн хамгааллын асуудалд ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсний хэмжээ, ажиллах, амрах хугацаа, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлт, орон сууцны нөхцөл зэрэг олон асуудлууд ордог.

*Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөл* сайн бол ажиллагчдийн биеийн эрүүл мэнд сайн, ажлын бүтээмж өндөр, цалин хөлс хангалттай байдаг. Харин дээрх нөхцөл муу бол мэргэжлийн өвчин тусч, осолд өртөж, хөдөлмөрлөх чадвараа алдах магадлал нэмэгдэж, нийгмээс тусламж, дэмжлэг хүртэгч болох зэргээр орлого нь буурч амьдрал нь доройтдог ажээ.

**Цалин хөлс** нь ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн орлогын эх үүсвэр, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралын уг сурвалж нь болдог. Ажиллагчдын мэргэжлийн түвшин, ур чадвар, дадлага туршлага, бүтээл, ажлын үр дүнд тохирсон цалин хөлсийг ажил олгогч эзэд өгөх ёстой. Цалин хөлсний доод хэмжээг Засгийн газраас тогтоож, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах нь төрөөс ажиллагчдын нийгмийн хамгааллыг хангуулах үндсэн үүрэг нь байдаг. Компани, байгууллагын орлогын хувиарлалтын хамгийн эхний хэсэгт цалин хөлсийг олгох асуудал тусгагдаг бөгөөд энэ асуудлаа шийдвэрлэж чадахгүй бол тухайн хуулийн этгээд дампуурахад хүрдэг байна. Цалин хөлсний доод хэмжээ нь тэдний гэр бүлийн гишүүдийн амьжиргааны түвшинг хангахуйц байхаар тогтоогдох ёстой.

*Нийгмийн даатгалын шимтгэл*-ээр дамжуулан ажиллагчид хөдөлмөрлөх чадвар сайтай байхдаа ажил олгогч болон өөрийн зүгээс нийгмийн даатгалын санд хөрөнгө хуримтлуулж чадвал өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажил орлогогүй болох үед авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь амьдралд хүрэлцэхүйц байдаг.

*Ажиллах, амрах хугацаа* нь хөдөлмөр эрхлэж байгаа иргэдийн амьдралын баталгааг хангах, урт удаан наслах, өвчин зовлонгүй аж төрөх нэг нөхцөл нь болдог. Хэт удаан хугацаагаар ажилласнаар ядрах, ажлын бүтээл буурах, гологдол үйлдвэрлэх зэргээр эдийн засаг, эрүүл мэнд, сэтгэл зүйн хохирол учрахад хүрэх нэг нөхцөл болдог.

Орон байр ажиллагчдын нийгмийн хамгааллын үндсэн нөхцөлийн нэг нь орон байрны асуудал юм. Ая тухтай нөхцөлд амьдарч байгаа иргэдийн хөдөлмөрийн бүтээл өндөр, үр дүн сайтай, эрүүл энх байдаг бол орон сууцны хангалтгүй нөхцөлд ажиллагчид өвчлөл, хүчирхийлэлд өртөж, сэтгэл санаа, эд материалын хувьд хохирох нь элбэг байдаг ажээ.

Ажиллагчдын нийгмийн хамгааллын асуудалд ажил олгогч гол үүрэгтэй бөгөөд тэдний хүч, оюун ухаан, мэргэжил, чадварыг ашигласны төлөө ажиллах чадваргүй болсон нөхцөлд хэрэглэх хөрөнгийг хуримтлуулахад туслах ёстой. Энэ үүргийг хөдөлмөрийн хөлстэй харьцангуй хувь хэмжээгээр шимтгэл төлж сан байгуулах замаар нийгмийн даатгалын системээр дамжуулан шийдвэрлэх практик ихэнх оронд байдаг.

**Ажилгүйчүүдийн** нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх үндсэн арга нь ажлын байр бий болгох, мэргэжлийн сургалтанд хамруулах, ажиллах ур чадвар, урам зоригийг дэмжих, хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх асуудлыг төрийн бодлогоор дэмжих нь чухал.

*Ажлын байр бий болгоход* хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгоход эдийн засаг, татвар, зээлийн бодлогоор дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгөх нь үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, эздийн нийгмийн хамгааллыг шийдвэрлэхэд ихээхэн анхаарах хэрэгтэй гэсэн үг юм.

*Мэргэжлийн сургалтанд* ажиллагчдын ур чадварыг дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, давтан сургах, ажлын байрны мэдээллийн систем бий болгох, мэргэжлийн эрэлт, хэрэгцээг нарийвчлан тодорхойлох асуудлууд багтдаг.

Хувиараа хөдөлмөр эрхлэхэд эдийн засаг, удирдлагын мэдлэг эзэмшүүлэх, хөрөнгө, хүч, мэдлэг, дадлагаа хоршин ажиллах нөөц боломжийг илрүүлэх, санхүүгийн бичил зээл, тусламж үзүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх арга барилд суралцахад туслах нь чухал ач холбогдолтой. Харин тэднийг нийгмийн халамжид хамруулж хоол, унд өгч асарч халамжлах нь бэлэнчлэх сэтгэлгээнд сургах, төрийн халамжийн ачааллыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, өгөөж, хүртээмжийг бууруулах зэрэг олон сөрөг асуудлуудыг бий болгодог.

Нийгмийн хамгааллын тухай ойлголтыг өргөн утгаар нь авч үзэж байгаа нөхцөлд ажил хийх чадваргүй, бие даан амьдрах нөхцөл, боломж муу иргэдэд нийгмийн зүгээс тусламж, дэмжлэг үзүүлэх асуудал нэг хэсгийг эзлэдэг.

**Тусламж дэмжлэг хүртэгчид** болох хөдөлмөрлөх, бие даан амьдрах чадваргүй өтөл настнууд, өвчин эмгэгт өртөгчид, өнчин хүүхдүүд, орлогогүй гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхдээ тэтгэвэр, тэтгэмж олгох, хамгаалал үзүүлэх, асрах, халамжлах арга хэмжээг хэрэгжүүлдэг.

*Тэтгэврийг* Монгол улсын хуулиар ахмад настан, 60 хүрсэн иргэнд нийгмийн даатгалын сангаас болон халамжийн сангаас сар бүр олгож тэднийг орлогын эрсдлээс хамгаалдаг. Мөн 55 нас хүрсэн эмэгтэй өөрийн хүсэлтээр тэтгэврээ эрт тогтоолгох эрхтэй байдаг.

*Тэтгэмж* нь хүүхэд төрүүлсэн эхчүүд, нярай хүүхэдтэй, хүүхдээ асарч байгаа гэр бүлийн гишүүд, олон хүүхэдтэй өрх, өнчин хүүхэд үрчлэн авагчид, ихэр хүүхэд зэрэг төрөлт, хүүхэд асрах, хүмүүжүүлэхтэй холбоотой гэр бүл, иргэдийг эрсдлээс хамгаалахад чиглэгддэг.

*Нөхөн олговор тусламж* нь тахир дутуу иргэд, ахмад настны эрүүл мэнд, амьжиргааны хэвийн нөхцлийг хангахад чиглэгдсэн тусламж, дэмжлэгийг хамарч байдаг.

*Асрамжлах үйл ажиллагаа* нь бие даан амьдрах чадваргүй өтөл настан, өнчин хүүхэд, тахир дутуу иргэдийг байнгын амьдрах байр, хоол, хүнс, хувцсаар хангаж, эрүүл мэнд, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх үндсэн зорилготой.

*Халамжлах үйлчилгээ* нь амьдралын эрсдэлд өртөж ядарч доройтсон, өвдөж зовсон, тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүст хоол, хүнсний зүйл олгох, сэтгэл санааг нь дэмжих, амьдралын итгэл олгоход чиглэсэн нийгмийн шинжтэй үйл ажиллагаа байдаг.

Нийгмийн хамгааллын асуудлыг өргөн утгаар нь авч үзэж эдийн засаг, улс төр, нийгэм, эрх зүйн олон асуудлуудыг нэгтгэх асуудал өнөөгийн нөхцөлд төдийлөн түгээмэл биш, энэ хүрээнд хийгдсэн судалгаа, онол арга зүйн асуудлууд ч харьцангуй бага байна.

Харин явцуу утгаар нь ойлгож, хэрэгжүүлэх хандлага өнөөгийн нийгмийн сэтгэлгээнд давуутай мэдрэгдэж байгаа бөгөөд хөрөнгө, санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй, буурай хөгжилтэй орнуудын хувьд голлон баримталдаг зарчим юм.

Нийгмийн хамгааллын асуудлыг өргөн утгаар нь авч үзэхээс гадна явцуу хүрээнд ойлгож, хэрэглэх нь нэлээд түгээмэл байдаг.


Амьдралын явцад өтлөлт, осол, өвчлөлд өртөж хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд болон өнчин хүүхэд, бие, эрхтний эмгэгтэй хүмүүс, хүүхэд төрүүлсэн, олон хүүхэдтэй, бэлэвсэрсэн, орлогогүй гэр бүлд амьдралын бололцоо олгоход чиглэсэн тэтгэмж, тэтгэвэр олгох, асрамжлах, халамжлах үйлчилгээг нийгмийн хамгаалал гэж явцуу утгаар нь ойлгоно. 5

Нийгмийн хамгааллын асуудлыг явцуу хүрээнд ойлгож байгаа нөхцөлд Хэнийг хамгаалах вэ? Бүх иргэдийг хамгаалах уу? Ажил олгогч эздийг үү? Ажил хөдөлмөр эрхлэж байгаа хүмүүсийг үү? Хөдөлмөрийн чадваргүй эмзэг хэсгийнхнийг үү? гэсэн асуудал тавигдаж, зөвхөн эмзэг хэсгийнхнийг сонгон авахад хүргэдэг.

Монгол улсын хүн амын зөвхөн 20-30 хувьд нь нийгмийн хамгааллын систем үйлчилнэ гэсэн үг юм. Нийгмийн хамгааллыг явцуу хүрээнд авч үзсэнээр хамрах хүрээ нь тодорхой болохоос гадна үйлчилгээний нэр төрөл, үйл ажиллагааны чиглэл нь ч явцуурч зөвхөн хуримтлагдсан хөрөнгийг эмзэг хэсгийнхэнд хүргэх, хувиарлах асуудал яригддаг.

### Эмзэг хэсгийнхэнд хэнийг хамруулах вэ?

Нийгмийн халамжийн тухай хуулинд “нийгмийн эмзэг хэсэг” гэж бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дутуу хүн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон нэн ядуу амьдралтай ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй эх (эцэг), нэн ядуу амьдралтай хүнийг хэлнэ гэсэн байдаг.



Нийгмийн хамгааллыг *ᠣᠳᠠᠶᠢ ᠪᠣᠳᠠᠭᠠᠳ* нь авч үзэж, хэрэгжүүлэх асуудал өнөөдөр төдийлөн яригдахгүй харин *ᠶᠠᠳᠣᠪᠣ* хүрээнд нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийгмийн бодлого дахь хамгааллын асуудлаар дамжуулан хүн амын амьдралын хамгааллын асуудлыг авч үзэх Монголын нийгмийн хамгааллын үндсэн систем бүрэлдэж байна.





II байр  
С.Гантулга, оюутан  
МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль,  
Маркетингийн 2-р анги

## 12-сарын 1. Дэлхий нийтээрээ ДОХ-той тэмцэх өдөр

2004 оны 12-р сарын 1-ний дэлхий нийтээрээ ДОХ-той тэмцэх өдөр “Эмэгтэйчүүдийг ДОХ-оос хамгаалъя” уриан дор болж өнгөрлөө. Энэ өдөрт зориулан Монголын Хүн ам ба Хөгжил Нийгэмлэгийн дэргэдэх “Залуу хүн ам зүйч” клуб, МУИС-ын Оюутны Холбоо-Оюутан конгресс хамтран “ДОХ-бидний амьдралд” сэдэвт 5 өдрийн аянг 2004 оны 11-р сарын 27-ноос 12-р сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулав.

Аяны өдрүүдэд МУИС-ийн оюутны дотуур байрууд, хичээлийн байруудаар ДОХ-той тэмцэх видео ухуулга, сурталчилгааны ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

Энэ аяны хүрээнд МУИС-ийн нийт оюутнуудын дунд ЭССЭ-нийтлэлийн уралдаан зарласан бөгөөд, уралдаанд нийт 50 гаруй оюутан бүтээлээ ирүүлээ. Эдгээр бүтээлүүдээс МУИС-ын НШУС-ийн философийн 4-р ангийн оюутан Ж.Энхжаргал “Хэнд, яаж, ямар аргаар” сэдэвт бүтээлээрээ I байр, МУИС-ийн ЭЗС-ийн Маркетингийн 2-р ангийн оюутан С.Гантулга “Хүн төрөлхтөн, дэлхий ертөнцөд нүүрлэсэн аюул” бүтээлээрээ II байр, МУИС-ийн ЭЗС-ийн даатгалын 3-р ангийн оюутан Ш.Мөнхцэцэг “ДОХ-бидний амьдралд” бүтээлээрээ III байр эзэлж 5000-15000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнагдлаа. МУИС-ийн НШУС-ийн нийгмийн ажилтны 4-р ангийн оюутан Х. Ариунзул, МУИС-ийн МКС-ийн программ хангамжийн 1-р ангийн оюутан Ч.Сүхбаатар нарын бүтээл тусгай байрт шалгарав.

Сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаарт эхний 2 байрт шалгарсан оюутнуудын ЭССЭ-нийтлэлийг уншигч танд толилуулж байна.